

КапитронБанк ХХК

2009 оны 12 сарын 31-нээр
дуусгавар болсон жилийн
Санхүүгийн Тайлан

КапитронБанк ХХК
Байгууллагын мэдээлэл

Банкны үйл ажиллагаа
Эрхлэх зөвшөөрөл № 22

2001 оны 11 дүгээр сарын 12-нд МонголБанкнаас авсан.

Төлөөлөн Удирдах
Зөвлөл

Л.Дашдорж	Дарга
Б.Мэдрээ	Гишүүн
П.Мөнхсайхан	Гишүүн

Хяналтын зөвлөл

Ө.Хишгээ	Хөгжил финанс ББСБ-ын Гүйцэтгэх захирал
----------	---

Удирдлагын зөвлөл

П.Мөнхсайхан	Гүйцэтгэх Захирал
Ө.Одонсүрэн	Тэргүүн дэд захирал
Б.Алтанхуяг	Тайлан Бүртгэл, Хяналтын Газрын Захирал
Т.Алтанзул	Хэрэг Эрхлэх Газрын Захирал
А.Бүдээ	Иргэдийн Банкны Газрын Захирал
Б.Эрдэнэцэцэг	Бизнесийн Банкны Газрын Захирал
С.Ганболд	Хөрөнгө Удирдлагын Газрын Захирал
Н.Энхмаа	Эрсдлийн Удирдлагын Газрын Захирал

Байнгын хаяг

Капитрон Банк ХХК
Капитрон Банкны Барилга
Энхтайвны өргөн чөлөө
Сүхбаатар Дүүрэг, 1-р хороо,
Улаанбаатар хот,
Монгол улс

Аудитор

Итгэлт Аудит ХХК
Юнити төвийн байр, 1-р давхар
Оюутны гудамж-44
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо
Улаанбаатар-14210
Монгол улс

**2009 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах
удирдлагын хариуцлагын талаарх Мэдэгдэл**

Энэхүү тайлангийн 3 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурьдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь “КапитронБанк” Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн (“Банк” гэх) 2009 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлантай холбогдуулан Банкны удирдлага болон аудиторын үүрэг хариуцлагын ялгааг танилцуулах зориулалтаар хийгдсэн болно.

Удирдлага нь банкны санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй бөгөөд эдгээр стандартуудаар санхүүгийн тайлангууд нь 2009 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдал, тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг.

Санхүүгийн тайланг бэлтгэхэд удирдлага нь дараах зүйлсэд хариуцлага хүлээдэг. Үүнд:

- Тохиромжтой нягтлан бодох бүргэлийн бодлогоо сонгож, түүнийгээ тууштай мөрдөх
- Ул үндэслэлтэй, хянамгай шийдэл гаргах болон тооцоолол хийх
- СТОУС-ыг дагаж мөрдсөн эсэхээ дурьдаж, хэрэв материаллаг ялгаа буюу өөрчлөлт байгаа бол санхүүгийн тайланд тодруулж, тайлбарлах
- Банк ойрын ирээдүйд бизнесээ тасралтгүйгээр үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл нь тохиромжгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагааны зарчимд үндэслэж бэлтгэх

Түүнчлэн банкны удирдлага нь

- Дотоод хяналтын үр дүнтэй, тууштай систем боловсруулж, хэрэгжүүлж, ажиллуулах
- Банкны санхүүгийн байдлыг үнэн зөвөөр харуулахуйц нягтлан бодох бүртгэл хөтлөх
- Банкны нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхэд чиглэгдсэн байх
- Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Заль мэхний асуудал, алдаа болон бусад зөрчлийг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх зэрэг үүрэг хүлээдэг.

“КапитронБанк” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс 2009 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн энэхүү санхүүгийн тайланг гаргахыг 2010 оны 8 сарын 2-ны өдөр зөвшөөрч баталсан болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

П.МӨНХСАЙХАН

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Капитрон Банк ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд

Бид 5-аас 39 дүгээр хуудсанд үзүүлсэн КапитронБанкны 2009 оны 12 дугаар сарын 31-ний Үлдэгдэл тэнцэл, энэ өдрөөр дуусвар болсон жилийн орлогын тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй, бусад тайлбар тэмдэглэлүүдэд аудит хийлээ.

Санхүүгийн тайлангийн талаарх удирдлагын үүрэг хариуцлага

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, шударгаар толилуулах болон заль мэх, алдаанаас үүдэлтэй материаллаг буруу тайлагналаас ангид санхүүгийн тайлан бэлтгэхэд хүрэлцэхүйц дотоод хяналтыг тогтоон ажиллуулах үүрэг хүлээнэ.

Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитын ажилдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргаж та бүхэнд тайлагнах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх болон мэргэжлийн ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөхийг биднээс шаарддаг.

Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн мэдээ болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн үнэлгээг хийхтэй холбоотойгоор, аудитор банкны дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг тодорхойлохын тулд тухайн банкны санхүүгийн тайланг бэлтгэж, шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн санхүүгийн тайлагналыг ерөнхийд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцоолууд болон хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын ул үндэстэй бөгөөд тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан.

Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж итгэж байна.

Дүгнэлтийн тайлбар

Сангийн Сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтарсан тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу арилжааны банкны активыг үнэлэхэд хугацааны үзүүлэлт нь суурь хүчин зүйл, чанарын үзүүлэлт нь харгалзах хүчин зүйл болдог. Тус банк зээлдэгчдэд олгосон зээлийн эрсдлийг үнэлэхдээ зээлийн хугацааны ангилалын үзүүлэлтийг үндэс болгосон байна. Бид зээлийн чанарын үзүүлэлтээс үүдэн банкинд учирч болох эрсдлийг тооцоолох замаар санхүүгийн тайланд холбогдох тохируулгыг хийгээгүй болно.

Аудитын дүгнэлт

Бидний дүгнэлтээр, энд хавсаргасан санхүүгийн тайлангууд нь КапитронБанк ХХК-ийн 2009 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг өмнөх догол мөрөнд тайлбарласанаас бусад бүх материаллаг зүйлсийн хувьд Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Хороо (НББОУСХ)-ноос гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу шударгаар илэрхийлсэн байна.



Итгэлт Аудит ХХК
Монгол Улс
Лиценз № 009-1997

Огноо: _____

КАПИТРОНБАНК ХХК
2009 оны 12 сарын 31-нээрх

ҮЛДЭГДЭЛ ТЭНЦЭЛ

	Тэм	2009 мян.төг	2008 мян.төг
АКТИВ			
Мөнгөн хөрөнгө	3	11,813,215	8,914,681
Хадгаламж	3	4,415,680	2,552,345
Түргэн борлогдох үнэт цаас	4	2,621,743	-
Зээл ба урьдчилгаа /цэвэр/	5	75,221,317	84,507,618
Өмчлөх бусад хөрөнгө	6	2,527,037	437,464
Өмч, барилга, тоног төхөөрөмж	7	3,151,224	3,319,272
Биет бус хөрөнгө	8	278,749	353,561
Бусад актив	9	3,638,474	1,874,112
Орлогын албан татварын тооцоо		47,411	57,757
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	10	1,648,523	1,290,624
НИЙТ АКТИВ		105,363,373	103,307,432
ПАССИВ БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
Пассив			
Харилцах, хадгаламж	11	44,690,468	43,369,487
Дотоодын санхүүгийн байгууллагын хадгаламж	12	8,528,407	17,430,066
Монголбанкнаас авсан зээл	13	5,311,509	13,327,285
Бусад санхүүгийн байгууллагаас авсан зээл	14	-	1,786,750
Төслийн зээлийн эх үүсвэр	15	28,321,251	13,638,470
Баталгаанд тусгаарласан эх үүсвэр	16	1,435,947	832,609
Урьдчилж орсон орлого	17	2,168,219	1,952,864
Бусад пассив	18	2,092,284	1,592,435
Хоёрдогч өглөг	19	3,000,000	-
Нийт пассив		95,548,085	93,929,965
Өөрийн хөрөнгө			
Дүрмийн сан	20	8,000,548	8,000,548
Дахин үнэлгээний нэмэгдэл		332,100	332,100
Нийгмийн хөгжлийн сан		927	1,927
Хуримтлагдсан ашиг /(алдагдал)		1,481,713	1,042,891
Нийт өөрийн хөрөнгө		9,815,288	9,377,466
НИЙТ ПАССИВ БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		105,363,373	103,307,432

Баталсан:

Бэлтгэсэн:

П. Мөнхсайхан
Гүйцэтгэх Захирал

Б.Алтанхуяг
Тайлан Бүртгэл,
Хяналтын газрын Захирал

КАПИТРОН БАНК ХХК
2009 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон жилийн
ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

	Тэм	2009 мян.төг	2008 мян.төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	21	13,221,818	13,655,152
Хүүгийн болон түүнтэй адилтгах зардал	22	(10,635,887)	(9,057,365)
Цэвэр хүүгийн орлого		2,585,931	4,597,786
Үнэт цаас, валютын арилжааны цэвэр ашиг /(алдагдал)	23	104,440	(280,400)
Ханшийн тэгшитгэл	24	513,399	150,241
Үйл ажиллагааны бусад орлого	25	1,107,640	999,672
Цэвэр хүүгийн бус орлого		1,725,479	869,513
Үйл ажиллагааны орлого		4,311,410	5,467,299
Үйл ажиллагааны зардал	26	(2,791,205)	(2,574,091)
Үнийн бууралтын алдагдал	27	(1,055,037)	(2,188,569)
Бусад олз ба гарз			(42,026)
Үйл ажиллагааны ашиг /(алдагдал)		465,169	662,613
Орлогын албан татвар	28	(26,347)	(72,776)
Татварын дараахь цэвэр ашиг /(алдагдал)		438,822	589,837
Нэгж хувьцаанд ногдох ашиг			
Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг /(алдагдал) (төгрөгөөр)	29	54,853	73,730

Баталсан:

Бэлтгэсэн:

П. Мөнхсайхан
Гүйцэтгэх Захирал

Б.Алтанхуяг
Тайлан Бүртгэл,
Хяналтын газрын Захирал

КАПИТРОНБАНК ХХК
2009 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон жилийн
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Нийгмийн Хөгжлийн сан	Хуримтлаг- дсан ашиг (алдагдал)	Нийт дүн
	мян.төг		мян.төг	мян.төг	мян.төг
2008 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	8,000,548	332,100	2,577	463,558	8,798,783
Нэмж гаргасан хувьцаат капитал	-	-	-	-	-
Дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	589,838	589,838
Хуваарилсан ногдол ашиг	-	-	10,505	(10,505)	-
НХС-ийн зарцуулалт	-	-	(11,155)	-	(11,155)
2009 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	8,000,548	332,100	1,927	1,042,891	9,377,466
Нэмж гаргасан хувьцаат капитал	-	-	-	438,822	438,822
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	-	-	-
НХС-д хуваарилсан	-	-	-	-	-
НХС-ийн зарцуулалт	-	-	(1,000)	-	(1,000)
2009 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	8,000,548	332,100	927	1,481,713	9,815,288

Баталсан:

Бэлтгэсэн:

П. Мөнхсайхан
Гүйцэтгэх Захирал

Б.Алтанхуяг
*Тайлан Бүртгэл,
Хяналтын газрын Захирал*

10-39-р хуудсанд үзүүлсэн тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

КАПИТРОН БАНК ХХК
2009 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тэм	2009 мян.төг	2008 мян.төг
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Татварын өмнөх ашиг /(алдагдал)	465,169	662,613
<i>Тохируулга:</i>		
Элэгдэл, хорогдол	278,907	379,537
Зээлийн эрсдлийн нөөцийн зардал	827,839	2,013,268
Бусад активын үнийн бууралтын алдагдал	227,198	175,301
Хүүгийн орлого	(13,221,818)	(13,655,152)
Хүүгийн зардал	10,635,887	9,057,365
Хөрөнгийн оруулалтын үнийн өсөлт	(40,000)	-
Үндсэн хөрөнгө худалдсаны олз	(117)	(2,292)
Үйл ажиллагааны актив, пассивын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	(826,936)	(1,369,359)
<i>Ажлын капиталын өөрчлөлт</i>		
Зээл, урьдчилгааны өсөлт	8,460,129	(17,145,397)
Түргэн борлогдох үнэт цаас	(2,624,000)	947,754
Өмчлөх бусад хөрөнгө	(2,119,158)	(459,051)
Бусад активын (өсөлт)/бууралт	(832,864)	583,471
Хөрөнгө оруулалт	(317,899)	(10,437)
Харилцах данс ба хадгаламж	1,320,982	(1,249,846)
Бусад банкнаас татсан эх үүсвэр	(18,704,185)	(7,598,269)
Бусад эх үүсвэр	15,432,993	15,167,675
Бусад пассивын өсөлт	87,230	(78,218)
Ажлын капиталын цэвэр өөрчлөлт	703,227	(9,842,318)
Хүлээн авсан хүү	12,092,705	12,738,303
Төлсөн хүү	(10,155,018)	(8,795,990)
Эрсдлийн сангаас хаасан зээл	822	-
Төлсөн орлогын албан татвар	(15,999)	(116,094)
	1,922,510	3,826,219
Үндсэн үйл ажиллагаанаас бий болсон /(түүнд шингэсэн) цэвэр мөнгөн гүйлгээ	1,798,801	(7,385,458)

10-39-р хуудсанд үзүүлсэн тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно.

КАПИТРОН БАНК ХХК
2009 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (үргэлжлэл)

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

Худалдан авсан үндсэн хөрөнгө	(40,851)	(839,168)
Худалдсан үндсэн хөрөнгө	4,919	-

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд ашигласан цэвэр мөнгөн гүйлгээ	(35,932)	(839,168)
--	-----------------	------------------

САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

Хувьцаа гаргалтын орлого	-	-
Хуваарилсан ногдол ашиг	-	-
Нийгмийн хөгжлийн сангийн зарцуулалт	(1,000)	(650)
Хоёрдогч өглөг	3,000,000	-

Санхүүгийн үйл ажиллагаанаас бий болсон цэвэр мөнгөн гүйлгээ	2,999,000	(650)
---	------------------	--------------

Тайлант жилд бий болсон нийт цэвэр мөнгөн гүйлгээ	4,761,869	(8,225,276)
--	------------------	--------------------

Мөнгө, түүнтэй адилтгах зүйлсийн оны эхний үлдэгдэл	11,467,026	19,692,303
--	-------------------	-------------------

Мөнгө, түүнтэй адилтгах зүйлсийн оны эцсийн үлдэгдэл	3 16,228,895	11,467,026
---	---------------------	-------------------

Баталсан:

Бэлтгэсэн:

П. Мөнхсайхан
Гүйцэтгэх Захирал

Б.Алтанхуяг
*Тайлан Бүртгэл,
Хяналтын Газрын Захирал*

КАПИТРОНБАНК ХХК
2009 оны 12 сарын 31-нээрх

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ

Эдгээр тэмдэглэлүүд нь хавсаргасан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг бөгөөд тэдгээр тайлантай хамт уншигдана.

1. Байгууллагын талаарх мэдээлэл ба үндсэн үйл ажиллагаа

Капитронбанк нь Монголбанкны Ерөнхийлөгчийн 2001 оны 545 тоот тушаалын дагуу олгогдсон 22 тоот банк байгуулах зөвшөөрлийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр, дараахь үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэйгээр байгуулагдсан.

- Мөнгөн хадгаламж, зээл, төлбөр тооцоо
- Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах
- Үнэт зүйл хадгалах
- Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөмж мэдээлэл өгөх

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2002 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 279 тоот тушаалаар дараахь үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нэмж олгосон:

- Өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд батлан даалт гаргах
- Үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах
- Гадаад төлбөр тооцоо эрхлэх энгийн
- Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх

Капитрон банкны Хувь нийлүүлэгчдийн хурлын 2006 оны 3-р сарын 02-ны өдрийн 02 тоот тогтоол, Монголбанкны зөвшөөрлийн дагуу 2006 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон арилжааны Интербанкийг тус банктай нэгтгэсэн.

Банкны хувь нийлүүлэгчид 2009 оны 12 дугаар 31-ны байдлаар банкны нийт хувьцааны 49.05%-ийн Монгол Улсын иргэн Балбарын Мэдрээ, 46.33%-ийг Пүрэвжавын Мөнхсайхан, 4.62%-ийг Худалдаа Хөгжлийн Банк эзэмшиж байна.

2009 оны 12 сарын 31-нээр тус Банк нь 7 салбар, 9 тооцооны төв, 1 хадгаламжийн касстай, 203 ажилтан (2008 онд: 208)-тай байсан.

2. Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Хураангуй

Эдгээр санхүүгийн тайлангуудыг гаргахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл 2010 оны 4 дугаар сарын 6-нд зөвшөөрсөн болно. Тус банк нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн дараахь бодлогуудыг баримталсан байна. Үүнд:

(а) Даган мөрдөлтийн мэдэгдэл

Эдгээр санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Хороо (“НББОУСХ”) ноос гаргаж, мөрдүүлсэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”) болон НББОУСХ-ны Тайлбарын Байнгын Хорооноос гаргасан тайлбарын дагуу бэлтгэгдсэн байна.

КАПИТРОНБАНК ХХК
2009 оны 12 сарын 31-нээрх

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ- (үргэлжлэл)

(б) Санхүүгийн тайлан бэлтгэсэн үндэслэл

Санхүүгийн тайлангууд нь мянгачилсан оронгоор, төгрөгөөр илэрхийлэгдсэн. Төгрөг нь тус банкны хэмжих хэрэгсэл болно. Зах зээлийн бодит үнээрээ бүртгэгдсэн, арилжаалах зориулалтаар эзэмшиж буй үнэт цаас болон борлуулах боломжтой хөрөнгө оруулалтын үнэт цаас зэрэг санхүүгийн хөрөнгө, өр төлбөрөөс бусад зүйлсийн хувьд уг санхүүгийн тайлангууд нь түүхэн өртөгт суурилан бэлтгэгддэг. Тус Банк нь нягтлан бодох бүртгэлийн бодлогоо тууштай мөрдсөн бөгөөд энэ нь өмнөх жилд ашигласан бүртгэлийн бодлоготой нийцэж байна.

(в) Гадаад валютаарх ажил гүйлгээ

Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээнүүдийг гүйлгээ хийгдсэн өдрийн албан ханшаар хөрвүүлдэг. Түүхэн өртгөөрөө тусгагдсан гадаад валютаарх мөнгөн хөрөнгө, өр төлбөрийг тухайн өдрийн албан ханшаар хөрвүүлдэг. Хөрвүүлэлтээс үүдсэн гадаад валютын ханшийн зөрүүг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Түүхэн өртгөөрөө тайлагнагдсан гадаад валютаарх мөнгөн бус хөрөнгүүдийг ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлдэг. Зах зээлийн бодит үнээрээ тусгагдсан гадаад валютаарх мөнгөн бус хөрөнгүүдийг үнэ цэнийг нь тодорхойлсон өдрийн гадаад валютын ханшаар төгрөгт хөрвүүлдэг.

(г) Санхүүгийн хэрэгслүүд

(i) Ангилал

Арилжааны хэрэгслүүд нь ерөнхийдөө ашиг олох зорилгоор богино хугацаанд Банкны эзэмшиж буй зүйлс юм.

Олгосон зээл ба урьдчилгаа нь ашиг олох зорилгоор богино хугацаагаар гаргаснаас бусад Банкнаас зээлдэгчдэд мөнгө олгох замаар бий болгосон зээл, авлага юм. Энэхүү олгосон зээл авлага нь банкинд болон хэрэглэгчдэд олгосон зээл, урьдчилгаанаас бүрддэг.

Дуусвар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө гэдэг нь тогтмол буюу тодорхойлогдохуйц төлбөртэй ба Банк дуусвар хугацаа хүртэл нь эзэмших боломжтой санхүүгийн хөрөнгүүд юм.

Худалдах боломжтой хөрөнгө гэдэг нь тус банкнаас гаргасан арилжааны зориулалтаар эзэмшээгүй буюу дуусвар хугацаа хүртэл нь эзэмшихгүй санхүүгийн активууд юм.

(ii) Анхдагч хүлээн зөвшөөрөлт

Банк нь санхүүгийн хэрэгслүүдийг худалдан авах буюу гаргахдаа анхлан гүйлгээний өртгийг агуулсан өртгөөр нь хэмждэг.

КАПИТРОНБАНК ХХК
2009 оны 12 сарын 31-нээрх

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ- (үргэлжлэл)

(iii) Дараах үеийн хэмжилт

Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараа идэвхтэй зах зээл дээр зах зээлийн санал болгох үнэгүй бөгөөд зах зээлийн бодит үнийг тодорхойлох боломжгүй хөрөнгүүдээс бусад бүх арилжааны хэрэгсэл, худалдах боломжтой хөрөнгүүд нь зах зээлийн үнээрээ хэмжигдэн, анхны өртгөөс үнийн бууралтын алдагдлыг хассан цэвэр өртгөөр тусгагддаг.

Арилжааны бус бүх санхүүгийн өр төлбөр, олгосон зээл урьдчилгаа, дуусвар хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө зэрэг нь үнийн бууралтын алдагдлыг хассан хорогдуулсан өртгөөрөө хэмжигддэг. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн аргаар тооцоолдог. Анхны гүйлгээний өртгийг багтаасан урамшуулал ба хөнгөлөлт нь холбогдох хэрэгслийн дансны үнэнд багтдаг бөгөөд тухайн хэрэгслийн үр ашигт хүүгийн түвшинд суурилан элэгддэг.

(iv) Онцгой хэрэгслүүд

Санхүүгийн онцгой хэрэгсэлд зориулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тэмдэглэлийг үзнэ үү.

(д) Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгө нь гар дээрх бэлэн мөнгөний үлдэгдэл, МонголБанк болон бусад банкинд харилцах, хадгаламжийн үлдэгдлээс бүрдэнэ. Мөнгөтэй адилтгах зүйл нь худалдан авснаас хойш нэг сарын хугацаатай, Монголбанкинд буцаан хөнгөлөлттэйгээр арилжаалах боломжтой Төв Банкны үнэт цаасыг багтаасан, худалдан авснаас хойш гурван сар буюу түүнээс богино хугацаатай, түргэн хөрвөх хөрөнгө оруулалтын үнэт цаас юм.

(е) Зээл, урьдчилгаа ба өмчлөх бусад хөрөнгө

Тус банкны олгосон зээл ба урьдчилгаа нь зээл ба авлагаар ангилагдсан. Зээлийн болон зээлийн хүүгийн эргэн төлөлтийн тооцоогоор бусдаас өмчлөлдөө шилжүүлэн авсан, худалдан борлуулах зориулалттай хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг өмчлөх бусад хөрөнгөөр ангилан тайлагнадаг. Эргэн төлөгдөхөөр тооцоолсон дүнг тусгах зорилгоор зээл, урьдчилгаа ба өмчлөх бусад хөрөнгийг нөөцийг цэвэрлэсэн цэвэр дүнгээр тайлагнадаг (нягтлан бодох бүртгэлийн бодлого (i)-ыг үзнэ үү).

КАПИТРОНБАНК ХХК
2009 оны 12 сарын 31-нээрх

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ- (үргэлжлэл)

(ё) Өмч, Барилга, Тоног төхөөрөмж

(i) Өртөг

Өмч, барилга, тоног төхөөрөмж нь өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон үнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр тайлагнагддаг. Өмч, барилга, тоног төхөөрөмжийн анхны өртөг нь худалдан авсан үнэ, импортын татвар, эргэн төлөгдөхгүй худалдан авалтын татвар, зориулалтын ашиглалтын нөхцөл, байршилд авчрахтай холбоотой бусад зардал зэргээс бүрдэнэ. Өмч, барилга, тоног төхөөрөмжийг ашиглалтанд оруулсанаас хойш гарсан урсгал болон их засвар, үйлчилгээний зардал гэх мэт зарцуулалтууд нь зардал гарсан жилийн орлогоос суутгагддаг. Өмч, барилга, тоног төхөөрөмжийн зүйлсийн ашиглалтаас олж болох ирээдүйн эдийн засгийн өгөөжийг уг зарцуулалтууд нь нэмэгдүүлж байгаа нь батлагдаж байгаа тохиолдолд эдгээр зарцуулалтууд нь өмч, барилга, тоног төхөөрөмжийн нэмэгдэл өртөг болон капиталждаг.

(ii) Элэгдэл

Элэгдлийг өмч, барилга, тоног төхөөрөмжийн тогтоосон ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар байгуулж, орлогын тайланд зардлаар харуулдаг. Тогтоосон ашиглалтын хугацаа нь дараах байдалтай байна:

<input type="checkbox"/> Барилга	40 жил
<input type="checkbox"/> тээврийн хэрэгсэл	10 жил
<input type="checkbox"/> конторын тоног төхөөрмж	10 жил
<input type="checkbox"/> компьютер	3-5 жил

(ж) Биет бус хөрөнгө

(i) Өртөг

Банк нь программ хангамж, хөрөнгө эзэмших эрхийг биет бус хэмээн хүлээн зөвшөөрдөг. Биет бус хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан хорогдуулга болон үнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр тайлагнагддаг. Биет бус хөрөнгийн анхны өртөг нь худалдан авсан үнэ, эргэн төлөгдөхгүй худалдан авалтын нэмэгдсэн өртгийн татвар, зориулалтын ашиглалтын нөхцөлд тохируулан суурилуулахтай холбоотой бусад зардал зэргээс бүрдэнэ.

(ii) Хорогдуулга

Хорогдуулгыг биет бус хөрөнгийн тогтоосон ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар байгуулж, орлогын тайланд зардлаар харуулдаг. Тогтоосон ашиглалтын хугацаа нь дараах байдалтай байна:

<input type="checkbox"/> программ хангамж	3 жил
<input type="checkbox"/> Бусад	2-10 жил

КАПИТРОНБАНК ХХК
2009 оны 12 сарын 31-нээрх

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ- (үргэлжлэл)

(з) Дуусаагүй барилга

Дуусаагүй барилга нь бүрэн дуусаагүй шинэ барилгыг барьж байгуулах ажлын өртгийг илэрхийлнэ. Барилгыг барих хугацаанд дуусаагүй барилгад ямар нэгэн элэгдэл байгуулдаггүй.

(и) Үнийн бууралт

Үнийн бууралт үүссэн тухай биет нотолгоо байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор банкны хөрөнгийн дансны үнийг балансын өдөр тус бүрээр шалгадаг. Ийм шинж тэмдэг байгаа бол тухайн хөрөнгийн эргэн нөхөгдөх боломжит дүнг тооцдог.

(i) Гаргасан зээл болон урьдчилгаа

Зээл ба урьдчилгаа нь эргэн төлөгдөхөд учирч болзошгүй эрсдлээс хамгаалах тусгай болон ерөнхий нөөцийг хассан цэвэр дүнгээр илэрхийлэгдсэн. Зээл урьдчилгааны үлдэгдлийн байнгын шалгалтад үндэслэн, түүний үнэ нь бодитойгоор буурч буй нь тодорхойлогдсон зээл ба урьдчилгааны дансны үнийг эргэн нөхөгдөх боломжтой дүн хүртэл нь бууруулж, тусгай нөөцийг байгуулдаг. Ижил төрлийн зээл ба урьдчилгааны багцын дансны үнийг балансын өдрөөрх тооцоолсон эргэн төлөгдөх боломжтой дүн хүртэл нь бууруулж ерөнхий нөөцийг байгуулдаг. Нөөцийн өсөлтийг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Зээл эргэн төлөгдөхгүй нь тодорхой болмогц бүх шаардлагатай эрх зүйн горимуудыг хийж гүйцэтгэн, эцсийн алдагдлыг тооцсоны дараа зээлийг шууд данснаас хасдаг.

Балансны өдрөөс хойш үнийн бууралтын алдагдлын дүн буурвал бууруулж бүртгэсний дараа тохиолдсон үйл явдалтай холбогдож бууруулсан бичилт буюу нөөцийг орлогын тайлангаар дамжуулан буцаан бүртгэдэг.

(ii) Өмчлөх бусад хөрөнгө

Төлөгдөх хугацаа нь хэтэрсэн зээлийн үндсэн өр ба хүүгийн төлбөрийг барагдуулах зорилгоор компанийн эзэмшилд бүрэн шилжүүлэн авсан, борлуулах зориулалттай хөрөнгийг өмчлөх бусад хөрөнгө хэмээн хүлээн зөвшөөрдөг. Өмчлөх бусад хөрөнгийг өмчлөлд авсанаас хойш Монгол банкны ерөнхийлөгч ба Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталсан журмын дагуу борлогдоогүй хугацаа болон чанарт нь суурилан эрсдлийн нөөц байгуулдаг. Өмчлөх бусад хөрөнгийг өмчлөлд бүртгэсэн өртгөөс эрсдлийн нөөцийг хассан цэвэр дүнгээр санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрдөг.

Нөөцийн өсөлтийг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Хөрөнгө борлогдохгүй нь тодорхой болмогц тухайн хөрөнгийг борлуулах боломжит үнэ хүртэл нь бууруулж, үнийн бууралтын нэмэлт нөөцийг хүлээн зөвшөөрдөг.

Балансны өдрөөс хойш үнийн бууралтын алдагдлын дүн буурвал бууруулж бүртгэсний дараа тохиолдсон үйл явдалтай холбогдож бууруулсан бичилт буюу нөөцийг орлогын тайлангаар дамжуулан буцаан бүртгэдэг.

КАПИТРОНБАНК ХХК
2009 оны 12 сарын 31-нээрх

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ- (үргэлжлэл)

(iii) Бусад активууд

Эргэн нөхөгдөх боломжтой дүн нь хөрөнгийн борлуулах цэвэр боломжит үнэ ба ашиглалтанд байгаа үнэ цэнийн томоохон хувийг эзэлдэг. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн тухайн үеийн зах зээлийн үнэлгээ болон тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдлийг тусгадаг татварын өмнөх хөнгөлөлтийн түвшинг ашиглан тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ хүртэл нь бууруулж ашиглалтанд байгаа үнэ цэнийг үнэлнэ. Мөнгөний орох урсгал бий болгодоггүй, бусад хөрөнгөөс тусдаа хөрөнгүүдийн хувьд эргэн нөхөгдөх дүнг тухайн хөрөнгийн харьяалагдаж буй мөнгө бий болгох нэгжийнх нь хувьд тодорхойлдог. Хөрөнгийн эсвэл мөнгө бий болгох нэгжийн дансны үнэ нь эргэн нөхөгдөх үнээсээ давсан үед үнийн бууралтын алдагдлыг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Эргэн нөхөгдөх дүнг тодорхойлоход ашигласан тооцоололд өөрчлөлт орсон бол үнийн бууралтын алдагдлыг буцаан бүртгэдэг. Үнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрөөгүй бол тодорхойлогдсон элэгдэл хорогдлыг хассан цэвэр дансны өртгөөс тухайн хөрөнгийн дансны үнэ хэтрэхгүй байх нөхцөлд үнийн бууралтын алдагдлыг буцаадаг. Үнийн бууралтын бүх буцаалтыг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

(й) Арилжааны бус санхүүгийн өр төлбөр

Арилжааны бус санхүүгийн өр төлбөр гэдэгт харилцагчид, бусад санхүүгийн байгууллагаас татсан харилцах, хадгаламж, хүү бүхий зээллэг болон бусад өглөгүүд орно. Арилжааны бус өр төлбөрийг анх өртгөөр нь тусгадаг. Анхдагч хүлээн зөвшөөрөлтөөс хойш тэдгээр нь хорогдуулсан өртөг буюу өртөг болон үлдэх өртгийн хоорондын зөрүүгийн хамт тусгагдан, үр ашигт хүүгийн аргаар тухайн хэрэгслийн эзэмших хугацааны турш орлогын тайланд хүлээн зөвшөөрөгддөг.

(к) Нөөцүүд

Банк нь өмнөх үеийн үйл явдлын үр дүнд хууль ёсны буюу үр дүнт хариуцлага хүлээж буй болон эдийн засгийн үр өгөөжийн гарах урсгалд хариуцлагаа биелүүлэх шаардлагатай байх үед балансанд нөөцийг хүлээн зөвшөөрдөг. Нөлөөлөл нь материаллаг бол мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн зах зээлийн үнэлгээг тусгадаг татварын өмнөх хүүгийн түвшин болон тохиромжтой бол тухайн өр төлбөрт хамааралтай эрсдлээр ирээдүйн хүлээгдэж буй мөнгөн урсгалыг дискаунтчилах замаар нөөцийг тодорхойлдог.

КАПИТРОНБАНК ХХК
2009 оны 12 сарын 31-нээрх

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ- (үргэлжлэл)

(л) Орлого

(i) Хүүгийн орлого

Хүүгийн орлого ба зардлыг хуримтлуулан бүртгэж, хөрөнгийн үр ашигт өгөөжийг харгалзан орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Хүүгийн орлого зардал нь хөнгөлөлт буюу урамшуулал, хүү бүхий хэрэгслийн дансны үнэ болон үр ашигт хүүгийн түвшний сууриар тооцсон дуусгавар хугацаан дахь дүнгийн хоорондын зөрүүний элэгдүүлэлт, хорогдлыг агуулдаг. Үндсэн дүн эсвэл хүү нь эргэн төлөгдөх нь эргэлзээтэй болсон үед хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрөхийг хойшлуулдаг. МонголБанкны шаардлагын дагуу хүүгийн төлбөр нь 3 сараар хугацаа хэтэрсэн тохиолдолд хүүг хүлээн зөвшөөрөхийг зогсоодог. Хүүг хүлээн зөвшөөрөхийг зогсоосон үед холбогдох хүүгийн авлагыг данснаас хасдаг. Хүүг хүлээн зөвшөөрөхийг зогсоосноос хойш хүүг мөнгөн сууриар хүлээн зөвшөөрдөг. Эргэн төлөгдөх эргэлзээтэй байдал арилсан үед хүүгийн орлогыг дахин аккруэль сууриар хүлээн зөвшөөрдөг.

(ii) Төлбөр хураамжийн орлого

Үзүүлсэн санхүүгийн үйлчилгээндээ хэрэглэгчдээс төлбөр хураамжийг авдаг. Төлбөр хураамжийн орлогыг холбогдох үйлчилгээг үзүүлэх үед хүлээн зөвшөөрдөг.

(iii) Түрээсийн орлого

Түрээслэсэн хөрөнгийн түрээсийн орлогыг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Түрээсийн урамшууллыг нийт түрээсийн орлогын салшгүй хэсэг болгон хүлээн зөвшөөрдөг.

(м) Үйл ажиллагааны түрээсийн төлбөр

Түрээсийн зардлыг түрээсийн хугацааны турш шулуун шугамын аргаар орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Түрээсийн урамшууллыг нийт түрээсийн зардлын салшгүй хэсэг болгон орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

(н) Орлогын татвар

Тайлант жилийн ашиг эсвэл алдагдалд ногдох орлогын татвар нь тайлант үеийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг. Өмчөөр шууд хүлээн зөвшөөрөгдөх нөхцөл бүхий зүйлстэй холбоотой татварыг өмчөөр хүлээн зөвшөөрдөг. Үүнээс бусад тохиолдолд орлогын татварыг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Тайлант үеийн татвар нь балансын өдрөөр хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувийг ашиглан тооцсон тухайн жилийн татвар ногдох орлогод ногдуулсан татварын өглөг болон өмнөх жилүүдийн татварын өглөгт хийсэн залруулга болно.

КАПИТРОНБАНК ХХК
2009 оны 12 сарын 31-нээрх

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ- (үргэлжлэл)

Балансын өр төлбөрийн аргыг ашиглан, санхүүгийн тайлангийн зорилгоор тооцоолсон дүн болон татварын зорилгоор тооцоолсон хөрөнгө өр төлбөрийн дансны үнийн дүнгийн хоорондох түр зөрүүгээр хойшлогдсон татварыг тооцоолдог. Нягтлан бодох бүртгэлийн ашиг болон татвар ногдох орлогод нөлөөлөхгүй хөрөнгө, өр төлбөрийн анхдагч хүлээн зөвшөөрөлттэй холбоотой түр зөрүүнд хойшлогдсон татварыг тооцоолдоггүй. Тооцоолсон хойшлогдсон татварын дүнг балансын өдрөөрх татварын батлагдсан хувийг ашиглан, хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийн хэрэгжилт буюу төлбөрийн таамаглаж буй хэв шинжид үндэслэн тооцно. Хойшлогдсон татварын хөрөнгө нь ирээдүйн татвар ногдох орлогод ашиглагдах боломжтой тохиолдолд л балансад хүлээн зөвшөөрөгддөг. Холбогдох татварын өгөөж нь хэрэгжих боломжгүй тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгө нь буурдаг.

(о) Ажиллагсдын тэтгэмж

i) Түр хугацааны ажилчдын тэтгэмж

Богино хугацаат ажилчдын тэтгэмж нь хөнгөлөлтгүй сууриар хэмжигддэг бөгөөд ажилчдын ажил гүйцэтгэсэн тайлант үед нь зардлаар бүртгэдэг.

Хэрэв ажилчдын гүйцэтгэсэн ажлын үр дүнгээс үүдэн банк хуулийн дагуу шагналт цалин өгөх хариуцлага хүлээх болон шагналт цалингийн дүнг үндэслэлтэй тооцоолох боломжтой үед тооцоолсон дүнгээр богино хугацаат шагналт цалингийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

ii) Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал

Монгол улсын хуулийн дагуу нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ёстой бөгөөд уг зардлыг гарсан тухайн үед нь орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

(ө) Бодлогын өөрчлөлт

2009 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн Монголбанкны Ерөнхийлөгч ба Сангийн сайдын хамтарсан 125/50 тоот тушаалаар “Активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах журам”-д өөрчлөлт оруулсан. Үүнд:

- Зээлийн гэрээний хугацаа 1 удаа сунгагдсан бол зээлийн ангиллыг хэвээр үлдээх ба зээлийн гэрээний хугацааг 2 дахь удаагаа сунгаж байгаа тохиолдолд зээлийн ангиллыг нэг шатлалаар бууруулна.
- Өмнөх журамд 181-270 хоногийн хугацаа хэтрэлттэй зээлийг эргэлзээтэй, 271 хоногоос дээш хугацаа хэтрэлттэй зээлийг муу зээлээр ангилдаг байсныг өөрчилж, 181-360 хоногийн хугацаа хэтрэлттэй зээлийг эргэлзээтэй, 361-ээс дааш хоногийн хугацаа хэтрэлттэй зээлийг Муу зээлээр ангилахаар өөрчилсөн.

Өмнөх журамд Хэвийн бус зээлд 40%, Эргэлзээтэй зээлд 75%-ийн эрсдлийн нөөц байгуулдаг байсныг Хэвийн бус зээлд 25%, Эргэлзээтэй зээлд 50%-ийн эрсдлийн нөөц байгуулахаар өөрчилсөн.

КАПИТРОНБАНК ХХК
2009 оны 12 сарын 31-нээрх

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ- (үргэлжлэл)

3. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

МонголБанкны шаардлагын дагуу Банк нь МонголБанкинд харилцах дансны үлдэгдэлтэй байх ёстой бөгөөд энэ харилцах данс нь хүүгүй. Байвал зохих үлдэгдлийг мөнгөн хөрөнгө болон бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн дундаж үлдэгдэлд суурилан тодорхойлдог.

(а) Касс ба харилцах данс

	2009	2008
	мян.төг	мян.төг
Касс дахь бэлэн мөнгө		
Төгрөг	488,874	455,580
Гадаад валют	817,272	645,835
	1,306,146	1,101,415
Монголбанк дахь харилцах		
Төгрөг	1,129,589	2,333,215
Гадаад валют	1,727,803	1,946,440
	2,857,392	4,279,655
Арилжааны банк дахь харилцах		
Төгрөг	38,050	681,733
Гадаад валют	163,620	221,526
	201,669	903,259
Гадаадын банк дахь валют	5,939,496	2,630,352
Үнэт металл	1,508,512	-
Нийт мөнгө	11,813,215	8,914,681

(б) Мөнгөн хадгаламж

Арилжааны банк дахь хадгаламж		
Төгрөг	1,530,000	30,000
Гадаад валют	2,885,680	2,522,345
	4,415,680	2,552,345
	16,228,895	11,467,026

КАПИТРОНБАНК ХХК
2009 оны 12 сарын 31-нээрх

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ- (үргэлжлэл)

4. Түргэн борлогдох үнэт цаас

- (i) 2009 оны 12 дугаар сарын 31-нээр тус банк нь 1624 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 3,152 мянган төгрөгийн хямдруулалттай, 2010 оны 01 дүгээр сарын 06-нд дуусгавар болох Монголбанкны үнэт цаасыг худалдан авсан байсан.
- (ii) 2009 оны 12 дугаар сарын 14-нөөр 1 сая төгрөгний нэрлэсэн үнэтэй, жилийн 14%-н хүүтэй, 2 жилийн хугацаатай, 500 ширхэг бонд, 2009 оны 12 дугаар сарын 14-нөөр 1 сая төгрөгний нэрлэсэн үнэтэй жилийн 14.5%-н хүүтэй, 5-н жилийн хугацаатай 500 ширхэг бонд тус тусыг худалдан авсан байна.

		2009	2008
		мян.төг	мян.төг
Монголбанкны үнэт цаас	(i)	1,624,000	-
МИК-ийн бонд	(ii)	1,000,000	-
Үнэт цаасны үнийн бууралтын нөөц		(2,257)	-
Цэвэр хөрөнгө оруулалт		2,621,743	-

5. Зээл ба урьдчилгаа

	2009	2008
	мян.төг	мян.төг
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	79,244,068	88,280,068
Ажиллагсдад олгосон зээл	1,423,273	864,568
Удирдлагын зөвлөлийн гишүүдэд олгосон зээл	445,373	428,206
	81,112,713	89,572,842
Үнийн бууралтын нөөц	(5,891,396)	(5,065,224)
Цэвэр зээл ба урьдчилгаа	75,221,317	84,507,618

Зээл урьдчилгааны нийт үлдэгдэлд 7,933,490 мянган (2008 онд: 1,335,993) төгрөгийн чанаргүй зээлийн дүн багтсан.

2009 оны 12 сарын 31-ний байдлаар 104,208.4 сая (2008 онд: 104,505.1 сая) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг зээлийн үлдэгдлийн барьцаанд авсан байна.

КАПИТРОНБАНК ХХК
2009 оны 12 сарын 31-нээрх

